

## **“СОР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 03 сарын 18-ны өдөр

№21/02

Улаанбаатар хот

### **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3, «Сор» хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.28 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Сор” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 10 цагт «Сор» хувьцаат компанийн байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, санал авах хуудсыг 3 дугаар хавсралтаар баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2021 оны 04 дугаар сарын 08-ны өдрөөр тогтоож, хурлын товыг хурал болохоос 40-с доошгүй хоногийн өмнө зарлаж, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төслийг үнэт цаасны компаниудад хүргүүлэхээр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг нийтэд мэдээлэх өдөр 2021 оны 03-р сарын 23-ны өдөр байна.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Ишхүү овогтой Дариймааг томилсугай.
6. «Сор» хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд: Комиссын дарга: Д.Сүхээ

Гишүүд: Н.Баярмаа

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Комиссийн дарга: Гүйцэтгэх захирал Е.Булгансайхан

Гишүүд: Ц.Цэцгээ

8. "Cop" хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах, хэлэлцүүлэх асуудлын бэлтгэл хангахыг "Cop" хувьцаат компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.



"Cop" ХК-ийн ТҮЗ-ийн 2021 оны 03 дугаар  
сарын 18-ны өдрийн 21/02 тоот хурлын  
тогтоолын нэгдүгээр хавсралт

**«Cop» ХК-ний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал:**

1. Cop ХК-ний 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Сор" ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар  
сарын 18-ны өдрийн 21/02 тоот хурлын  
тогтоолын хоёрдугаар хавсралт

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх,  
Зохион байгуулах ажлын төлөвлөгөө.**

Д/д	Гүйцэтгэх ажлын утга	Хугацаа	Хариуцах эзэн
A.	<b>ХУРЛЫН МАТЕРИАЛ БЭЛТГЭХ</b>		
1	Сор ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэх	04/27	Ц.Цэцгээ
B.	<b>ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ</b>		
1	Хурлын зар сурталчилгаа гаргах	03/22	Г.Уянга
2	Хурлын танхимын зохион байгуулалт, тоног төхөөрөмжээр хангах, хурлын хэвийн явцыг хангах	04/28	Г.Уянга
3	Хурлын танилцуулга, саналын хуудсыг хэвлүүлэх	04/08	Г.Уянга
4	Тооллогын комиссыг байгуулж бэлтгэл хангуулах	04/27	Г.Уянга
5	Хурлын протокол хөтлөх ажлын хэсгийг байгуулж бэлтгэл хангуулах	04/27	Г.Уянга

Сор" ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар  
сарын 18-ны өдрийн 21/02 тоот хурлын  
тогтоолын гуравдугаар хавсралт

**"СОР" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

"СОР" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Өөрийн хурлын танхимд болно. Саналын худсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцонд тооцно. Хувьцаат компанийн хувьд бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд шинэ эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох итгэмжлэл олгох, эсхүл шинэ эзэмшигчийн өгсөн зааврын дагуу санал өгч болно.

Хувьцаа эзэмшигчийн эцэг/эхийн нэр.....

Нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар .....

Регистрийн дугаар .....

Санал өгөх хувьцааны тоо .....

Бүртгэсэн:/Үнэт цаасны компанийн нэр/ .....

Брокерийн овог ..... Нэр.....

№	Санал өгөх асуудлууд	Зөвшөөрсөн саналын тоо	Татгалзсан саналын тоо	Түдгэлzsэн саналын тоо
1	"Сор" ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах			

Брокер ...../гарын үсэг/

Хувьцаа эзэмшигч ...../гарын үсэг/

----- таслах шугам ----- таслах шугам -----

Таныг төлөөлөх хүний:

Овог ..... Нэр .....

Хувьцааны тоо .....

Регистрийн дугаар.....

Гарын үсэг .....

Санал авах хуудсыг ашиглах санамж:

- Санал авах хуудсыг засварласан, балласан тохиолдолд санал авах хуудас хүчингүйд тооцогдоно.
- Хувьцаа эзэмшигч нь 2021 оны 4-р сарын 27-ны өдрийн дотор хурлын материалтай танилцаад санал авах хуудсанд саналаа тоогоор өгч тооллогын комисст буцаан өгнө.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар 99287927 тоот утсаар лавлаж болно.
- Хэрэв та хуралд өөрийн биеэр оролцох бол санал авах хуудасны зураас шугам дагуулан тасалж аваад тасалбарын доод хэсгийг үнэн зөв бөглөн тооллогын комисст өгч үлдсэн хэсгийг хуралд авч ирнэ.
- Хэрэв та хуралд өөрийн биеэр оролцохгүй тохиолдолд саналын хуудсаа өөрийн харьяа брокер дилерийн компани дээр бөглөж үлдээнэ эсхүл төлөөлөх хүнийхээ овог, нэрийг дор бичих бөгөөд өөрийн санал авах хуудас, иргэний үнэмлэх, хувьцаа эзэмшиж буй баталгаа, итгэмжлэлийн хамт өгч ирүүлнэ.

Санал авах хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:

.....  
.....  
.....